

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХУРГЭХ ЗӨВЛӨМЖ			
№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	Хүүхэд хөгжүүлэх соёлын орон зайд өргөжүүлэхэд анхаарч, хамрах хүрээг тэлэх, сумдын Соёлын төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зөв зан үйл, ёс суртахуунтай иргэн бэлтгэх, соён гэгээрүүлэхэд	<p>Соёл, урлагийн газар, харьяа соёлын 7 байгууллага нь хүүхэд хөгжүүлэх соёлын орон зайд өргөжүүлэх, зөв зан үйл, ёс суртахуунтай иргэн бэлтгэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн 62 арга хэмжээнд 33845 хүнийг хамруулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Соёл, урлагийн газар нь "Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл" өвийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Найрамдлын Дархан өргөөтэй болсон. Тус гэрээр дамжуулан "Монгол гэр хэрхэн үүсэж хөгжсөн түүх", "Оюуны цэнгэл" уламжлалт наадгай, "Хөөрхөн Нада" хөлөгт наадгай, "Аман яруу найраг-оньсого", "Нада-тай цуг Найрамдлын Музейгээр аялай" зурагт комик, "Хорол, үйчүүр наадгай" хөтөлбөрийг зохион байгуулж 17,706 иргэдэд үйлчилсэн. Залуучууд театр нь улсын төсвийн 450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6x12 метрийн хэмжээтэй гадна зориулалтын лед дэлгэц, 16x10 метрийн хэмжээтэй зөөврийн тайзтай болж явуулын соёлын орон зайд бүрдүүлэв. Тус тайлан дээр 2024.06.01-ний өдөр Хүүхдийн баярын нэгдсэн үйл ажиллагаа болон бүжиг сонирхогч хүүхэд, өсвөр үеийнхний дунд "WE CAN DO IT" чөлөөт бүжгийн тэмцээнийг тус тус зохион байгуулав. Сурагчад урлагийн боловсрол олгох ажлын хүрээнд мэргэжил сурталчлах өдөрлөгийг Залуучууд театрын дуу, хөгжим ангийн уран бүтээлчид "Оюуны ирээдүй цогцолбор" сургуулийн 9 дүгээр ангийн 300 гаруй сурагчад 2024.05.20-ны өдөр, драм, бүжиг ангийн уран бүтээлчид 16 дугаар сургуулийн ахлах ангийн 200 гаруй сурагчад 2024.06.05-ны өдөр тус тус зохион байгууллаа. С.Маршакын зохиол Н.Баярцэнгэлийн найруулга "Муурын байшин" хүүхдийн жүжгийг шинээр найруулан тавьж нийт 23 удаа тоглож 6800 хүүхэд багачуудад үзүүлсэн. Монгол Улсын Консерватори, Залуучууд театр хамтран тус сургуулийн Ардын бүжгийн ангийн элсэлтийн шалгалтыг зохион байгуулав. Шалгалтад ЕБС-ын 7 дугаар ангийн 200 гаруй сурагч хамрагдаж 8 хүүхэд тэнцсэн. Номын сангийн уншигч, үйлчлүүлэгчдээ зориулан эрүүл мэндийн "Анхны тусламжийн хайрцаг", "Санал хүсэлт"-ийн хайрцагийг тус тус байршуулан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн. 	100%

		<p>7. Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын бүтээлч орон зайг бүрдүүлэх зорилгоор соёлын байгууллагууд соёлын боловсрол олгох орчин бүрдүүлж эхний хагас жилийн байдлаар нийт 27 боловсролын хөтөлбөрийг 5868 хүнийг хамруулсан.</p> <p>8. “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ыг Хүүхдийн номын ордонд нээж бий биелгээний сургалтыг 7 хоног зохион байгуулж нийт 13 хүүхэд хамрагдаж, Батламж гардууллаа.</p> <p>9. “Хөшиг нээгдэх бүрт-хүргэх нэг үг”, “Хүүхэд хөгжлийн хувийг бий болгох” уриан дор соёлын байгууллагууд нийт 36 арга хэмжээнд 8769 /давхардсан тоогоор/ хүнийг хамруулж цахим орчинд 10 арга хэмжээг 12,568 хүнд, Хүүхдийн хөгжил, хамгаалалд олсон орлогноосоо 3,812,230 төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>10. Шарын гол, Орхон, Хонгор сумын соёлын төв хүүхэд багачуудыг зөв зан үйл, ёс суртахуунтай иргэн байх, төлөвшүүлэхэд чиглэсэн 21 арга хэмжээг сумын ЕБС-ийн 1492 сурагчдын дунд зохион байгуулсан.</p> <p>11. Соёлын 7 байгууллага батлагдсан 30 төрлийн боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж байна. Мөн соёлын 6 байгууллагын дэргэдэх нийт 24 сургалт, дугуйландаа 790 суралцагч суралцсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Залуучууд театр нь драмын 2, дууны 1, хөгжмийн 4, бүжгийн 3, циркийн 1 нийт 11 дугуйлантай хамтран ажиллах гэрээ хийж дэмжин ажиллаж байна. Тус дугуйлангуудад нийт 114 хүүхэд суралцдаг. ➤ Шарын гол сумын Соёлын төв хүүхэд хөгжүүлэх 1 дугуйландаа 77 хүүхдийг хамруулсан. ➤ Орхон сумын Соёлын төв бүжиг, хөгжим, цахилгаан хөгжим зэрэг 3 дугуйландаа 52 хүүхдийг хамруулсан. Хонгор сумын Соёлын төв нь дуу, бүжгийн 2 дугуйландаа 32 хүүхдийг хамруулсан. ➤ Төв номын сан шатрын дугуйланг 2 удаа, Англи хэлний сургалтыг 2 удаа зохион байгуулж 36 хүүхдийг хамруулсан. <p>12. Хүүхдийн номын ордон нь Монгол хэл, бичиг-уран зохиол, Байгалийн ухаан, Гадаад хэл, Цахим ном-мэдээлэл, Book&coffee төрөлжсөн 5 танхимаар давхардсан тоогоор 485 хүүхдэд үйлчилж, 4068 ном хэвлэл болон хоцрогдол арилгах, бие даан суралцахад нь тусалж давтлага өгч үйлчилжээ.</p>	
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэсний цөөнх хүүхдүүдийн	<p>1. Соёл, урлагийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, СББӨ-ийг өвлөн уламжлагчид тус аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо, тусгай хэрэгцээт залуусын “Урам төв”-тэй</p>	

хөгжлийг дэмжих арга хэмжээг өргөжүүлэх, талуудтай хамтрах	<p>хамтран 2024.04.01-нээс эхлэн 18 хүртэлх насын 129 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд 6 удаа соёлын боловсролын хөтөлбөрөөр үйлчилсэн.</p> <p>2. Аймгийн Музейгээс харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан БРАЙЛ ҮСГЭН ТАЙЛБАР бэлтгэн гаргаж “Найрамдал”-ын танхимд байршуулав. Уг брайл хэвлэлийг Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны төв салбарт 250,000 төгрөгийн төсвөөр хэвлүүлсэн.</p> <p>3. Сул харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай шилийг 50,000 төгрөгөөр авч байршуулнаар музейгээр үйлчлүүлж буй харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан.</p> <p>4. Музейн нүүдлийн "Гэр үзэсгэлэн"-г хөгжлийн бэрхшээлтэй 98, Музейг танхимаар хөгжлийн бэрхшээлтэй 3 үзэгч үзэж танилцсан.</p> <p>5. Төв номын сангаас Тусгай хэрэгцээт бүлгийн уншигчдад үнэ төлбөргүй карт нээж, 500 гаруй хүнд үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>6. Мөн аймгийн ХХҮГ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж 24 иргэн оролцсон. Үр дүнд Төв номын санд “Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь” 60,0 сая төгрөгийн төслийг орон нутгийн хөгжлийн сангийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр болов. Ингэснээр тус аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 4578 иргэн буюу 4,7% нь соёлын үйлчилгээг авах боломж бүрдсэн.</p> <p>7. Хүүхдийн номын ордон нь хөгжлийн бэрхшээлтэй 48 хүүхэд, иргэнд “Үлгэртэй өдөр” арга хэмжээг зохион байгуулж “Чанга уншлага”, Мини театраар үйлчилсэн.</p> <p>8. Залуучууд театр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийтийн ариун цэврийн өрөөнүүдийг 400,000 төгрөгөөр засварлан тулц, бариулуудыг хийсэн.</p> <p>9. С.Маршакын зохиол Н.Баярцэнгэлийн найруулга “Муурын байшин” хүүхдийн шинэ жүжгийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Энэрэл” цогцолбор сургуулийн 400 гаруй сурагчид, багш ажилтнуудад үнэ төлбөргүй тоглож үйлчиллээ.</p> <p>10. Орхон сумын Соёлын төв байгууллагын үүдний орох хэсгийг налуу замтай болгосон. Аврах гарцын хаалга, ариун цэврийн өрөөг тэргэнцэртэй иргэдэд зориулан засварлах, стандартын зам гарцыг 6 дугаар сард хийхээр төлөвлөсөн.</p>	100%
--	--	------

		11. Соёл, урлагийн газар дарга Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах зөвлөлийн хуралд 2 удаа оролцож соёлын 7 байгууллагаас тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 2024 онд соёлын үйлчилгээ зохион байгуулах 28 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг танилцуулсан.	
3	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг өргөжүүлэх хүрээнд хүүхдэд зориулсан соёлын эрхийн бичгийг нэвтрүүлэхэд санаачлагатай ажиллах	<p>Хүүхдэд зориулсан соёлын эрхийн бичгийг нэвтрүүлэхэд тус газар төрийн өмчийн Соёлын 7 байгууллага, Дарханы зураач, урчуудын эвлэл, Дархан-Уул аймгийн Амьдралын Зөн Хараа ТББ-аас Дархан-уул аймгийн 16-18 насны иргэдэд соёлын эрхийн бичгээр үйлчлэх 44 арга хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэл, хөтөлбөр, зурагт хуудсуудыг нэгтгэн Соёлын яаманд хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Аймгийн Залуучууд театр Эрх мэдэл, хүний дотоод сэтгэлийг тодорхойлсон жужиг, ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгэгдсэн язгуур урлагийг таниулан сурталчлах ➤ Төв номын сан "Монгол баихархал", Эсгий урлал", "Хайрлахуйн ухаан", "Уран зангилаа" боловсролын хөтөлбөр ➤ Аймгийн Музей "Оюуны цэнгэл", "Хорол, Үйчүүр наадгай", "Нада-тай цуг Найрамдлын Музейгээр аялай", "Хөөрхөн Нада" хөлөгт тоглоом, "Өв соёл" танин мэдэхүйн сургалт, "Найрамдлын Дархан нутгаар" хотын аялал, ➤ Хүүхдийн номын ордон "Угийн бичгээ хөтөлцгөө", "Өв соёлоо мэдье", Уламжлалт тоглоом наадгай", "Эсгийн олбог", "Номын сангийн төрөлжсөн танхимиын үйлчилгээ", "Мөрөөдөх эрх", "Мэргэжлээ сонгоход тань туслая" ➤ Шарын гол сумын Соёлын төв "Өсвөр насны ХӨВГҮҮДЭД зориулсан суралт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, "Your fashion" хаягдал хувцасаар цоо загвар зохион бүтээх уралдаан, "Хүндлэл хайр" ахмадаа сонсьё өдөрлөг, "Дэвжээ" тэмцээн, "Зүү ороож хатгах оёдол", "Морин хуур" хөгжмийн боловсрол олгох хөтөлбөр, "Дөрвөн бэрх" наадам, ➤ Орхон сумын Соёлын төв Кино үзвэр үйлчилгээ, "Уламжлалт тоглоом, наадгай" боловсролын хөтөлбөр, Хөгжмийн сургалт, "Том хамарт одой" хүүхэлдэйн жужиг ➤ Хонгор сумын Соёлын төв Бий биелгээ, Хөгжмийн зэмсгийн мэдлэг олгох, Уламжлалт тоглоом наадгай, "Угийн бичиг хөтлөх арга зүй, давуу тал", "Мэдлэгээ хуваалцья" сургалтууд ➤ Дарханы зураач, урчуудын холбоо Уран зургийн үзэсгэлэн, Уран зургийн сургалт, Хөрөг зургийн үйлчилгээ, Канвас арт зургийн сургалт 	100%

		<ul style="list-style-type: none"> ➤ Дархан-Уул аймгийн Амьдралын Зөн Хараа ТББ "Амьдралын луужин", "Аюулгүй сонголт", "Санхүүгийн цагаан толгой", "Харилцааны урлаг", "Илтгэх урлаг", "Ятгах ур чадварын дасгалжуулалт" сургалт зэрэг хөтөлбөрүүдийг зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна. 	
4	Соёлын салбарт "насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдүүлж хүүхдийн хөдөлмөрийг бүрэн хориглох	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаарт Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг соёлын салбарын албан хаагчдад танилцуулж, Соёлын салбарт "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг мөрдүүлж ажиллахад хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн хөдөлмөрийг бүрэн хориглох тухай мэдээ мэдээлийг байгууллагын цахим хуудсанд 5-аас доошгүй удаа байршуулж олон нийтэд сурталчилсан.</p>	70%
5	Хүүхдэд соёлын үйлчилгээ үзүүлэгчдийн хүүхдийн эрхийн тухай ойлголтыг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд 10 арга хэмжээнд хүнийг 1223 хамруулж ажиллалаа. Үүнд:	<p>Хүүхдэд соёлын үйлчилгээ үзүүлэгчдийн хүүхдийн эрхийн тухай ойлголтыг нэмэгдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд 10 арга хэмжээнд хүнийг 1223 хамруулж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Тус газраас Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийг хэрэгжүүлж ажиллах тухай чиглэлийг соёлын байгууллагуудад албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тус газрын харьяа Залуучууд театр, сумдын Соёлын төвийн дэргэд хичээллэж буй 18 дугуйлангийн багш наарт болон 269 суралцагч хүүхдүүдэд, соёлын салбарын 10 албан хаагчид сургалтыг тус тус зохион байгуулж уг журмыг сурталчилсан. ➤ Соёлын байгууллагууд нь "Хөшиг нээгдэх бүрт хүргэх нэг үг" уриалгын хүрээнд уг журмын заалтуудыг сурталчилж байна. ➤ Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Биеийн тамир, спортын газартай хамтран Спортын тэмцээн уралдаан, Үдшийн цэнгүүн, Ойн арга хэмжээнүүд болон хүүхдийн хөгжлийг дэмжсэн 16 удаагийн урлагийн тогтолтын үеэр журмын хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөмж өгч ажилласан. Эхний хагас жилийн байдлаар гомдол, санал гарагүй болно. ➤ Залуучууд театрын хүүхдийн шинэ уран бүтээл "Муурын байшин" драмын жүжгийн бяцхан жүжигчид Цэц.мн сайттай хамтран "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй" аяныг дэмжсэн контент уриалга бэлтгэн цахим орчинд байршууллаа. 	100%

	<ul style="list-style-type: none"> ➤ Залуучууд театр нь Үе тэнгийн дээрхлэлтийн эсрэг, хүүхдийн хүмүүжлийн талаар Зохиолч Д.Намдагийн “Ядмаа” Уран сайхны киног 3 удаа гаргаж нийт 600 гаруй хүүхэд багачуудад үзүүллээ. ➤ Мөн аймгийн ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 төрлийн сургалтыг 2024.04.26-ны өдөр албан хаагчдад зохион байгуулав. ➤ ХЭҮК-ийн Дархан-Уул аймаг дахь референт Э.Болортuyaа нь Төв номын санд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” сэдвээр сургалт зохион байгуулж, ЕБС-ийн 24 сурагчийг хамруулсан байна. ➤ Төв номын сан нь хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ХГБХХГ-тай хамтран “Харилцаа ба ёс суртахуун” сэдэвт сургалтад 90 гаруй багш, сурагч, ажилтан, албан хаагчдыг хамруулж, соён гэгээрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан. ➤ Эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ, Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын газар, соёлын байгууллагуудтай хамтран “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгийг 2 дахь жилдээ зохион байгуулж 435 сурагчийг оролцуулав. ➤ Дархан-Уул аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын харьяа Хүүхэд хөгжлийн ордонд хүүхдийн Номын ордны салбар номын сан үйлчилгээ явуулж ЕБС, СӨББ-ын хүүхдүүдэд номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. ЕБС, СӨББ-тай хамтран Зөөврийн болон Нүүдлийн номын сан, Соёл олон нийтийн үйл ажиллагаа зэргийг хамтран зохион байгуулж байна. <p>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр соёлын байгууллагууд 19 хөтөлбөрийг зохион байгуулж нийт 5000 гаруй хүүхэд, иргэдэд хүргэлээ. Тус өдрийн үйл ажиллагааг зохион байгуулах зардалд аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 02-А/109 тушаалаар 36.869.300 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Нээлтийн хөтөлбөрт урлаг, спортын 21 үзүүлбэрт нийт 639 хүүхэд хамрагдаж, хоёрдугаар хэсгийн урлаг, спортын 20 үзүүлбэрт 4 байгууллагын 192 хүүхэд оролцлоо. ➤ Залуучууд театрын дэргэдэх “Шонходой” циркийн 18 жужигчин, “Эрмүүн” дугуйлангийн 28 сурагчдын хамтарсан тайлан тогтолцод нийт 46 хүүхэд оролцож 500 гаруй үзэгч үзлээ. ➤ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо, тусгай хэрэгцээт залуусын “Урам төв”-ийн 5 хүүхдийг оролцуулж алдаршуулсан. Мөн аймгийн Музейтэй хамтран 	
--	---	--

		<p>сонсоглын бэрхшээлтэй СББӨ-ийг өвлөн уламжлагч Х.Энхсарангийн уран бүтээлийн түр үзэсгэлэнг толилуулав.</p> <ul style="list-style-type: none"> ➤ "Монгол наадгай" хөлөгт тоглоомыг 5000 гаруй үзэгчдэд хүргэлээ. ➤ Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлтэй хамтран Open mics зохион байгуулав. 	
6	<p>Хүүхдэд зориулсан соёлын бүтээл, үйл ажиллагаанд /ном, гарын авлага, дуу, шүлэг, шторк, клип, кино, тэмцээн уралдаан/ зохисгүй үг хэрэглэх, гадаад үгийн шууд хэрэглэх зэрэгт тавих хяналтыг сайжруулах, монгол хэлний дархлааг хамгаалахад манлайлж ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Соёл, урлагийн газар, харьяа соёлын байгууллагууд Монгол хэл, бичгийн дүрмийн дасгал ажил, цахим толийг цахимд байршуулж 1533 хүнд хүргэсэн. ➤ "Хос бичигтэн" арга хэмжээний хүрээнд үндэсний бичиг үсгээ сурч эзэмшин түгээн дэлгэрүүлэх олон талт сургалт, үзэсгэлэн, нөлөөллийн 12 арга хэмжээнд 1092 хүүхдийг хамруулсан. ➤ Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд Эх хэл түүх соёлоо эрхэмлэн дээдэлсэн, эрүүл чийрэг, эх оронч, бүтээлч Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн 10 арга хэмжээг зохион байгуулсан байна. Тэдгээрт нийт 1035 хүүхдийг хамруулсан. ➤ Харьяа номын сангидтай хамтран үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд "Бийрэн бичлэг", "Уран уншлага"-ын сургалт, уралдааныг 8 удаа зохион байгуулж 79 хүүхдийг хамруулсан. ➤ Сурагчдын бийрэн бичлэгийн бүтээл болон 54 боть номоор үзэсгэлэн дэлгэж 62 сурагчийг хамруулав. ➤ Үндэсний бичгийн "Түргэн уншлага", "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэг, "Эх хэлээ эрхэмлье" сайхан бичгийн уралдаанд нийт 460 иргэнийг хамруулсан. ➤ "Яруу найргийн хур" анги нийтийн уран уншлагын уралдааныг зохион байгуулж 246 сурагч хамрагдалаа. ➤ Үсгээр үг бүтээх, үгийг үсэглэх, хоршоо үг олох зэрэг даалгавар бүхий "Үсэглэлийн хаад" уралдаанд 45 сурагч оролцлоо. 	100%

ТАЙЛАН БИЧСЭН:
СОЁЛ ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Б.ДОЛГОРМАА

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ